



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/ММ

Булган сум

“Гитар хөгжим”-ийн сургалт зохион байгуулахад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх заалт, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардал батлах тухай” А/360 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд, залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, хөгжмийн урлагаар хичээллэх, авьяас сонирхлоо хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор “Гитар хөгжим”-ийн сургалтыг зохион байгуулсугай.

2. “Гитар хөгжим”-ийн сургалтыг хүүхдийн Жаргалант зуслангийн сургалтын үйл ажиллагаатай уялдуулан аймгийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар, Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газартай хамтран зохин байгуулахыг тус газрын дарга нарт үүрэг болгосугай.

3. Сургалт зохион байгуулах сургагч багш нарыг сонгон шалгаруулж, хөгжмийн зэмсэг худалдан авах гэрээ байгуулж, ажиллахыг Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга (Г.Алдармөнх)-д даалгасугай.


4. Дээрх үйл ажиллагааг удирдлага зохион байгуулалтаар хангаж, хэрэгжилтийг танилцуулахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (М.Батчимэг)-д тус тус үүрэг болгосугай.

5. Сургалт зохион байгуулахад шаардагдах 20,640,000 (хорин сая зургаан зуун дөчин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Наранбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж



6325010572

Аймгийн Засаг даргын 2025 оны
06 дугаар сарын 12-ны/ний өдрийн
Х/АМ дугаар захирамжийн хавсралт



ГИТАР ХӨГЖИМ"-ИЙН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ ТӨСӨВ

Д/д	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	2	3	4	5	6
1	Сургалтын гитар	20ш	270,000	5,400,000	"ОЗЗО" ХХК-ийн DJL хөгжмийн академи
2	Сургалтын гитар	30ш	180,000	5,400,000	Иргэн Сандуйн Энхбат
3	Ахлах сургагч багшийн зардал	1ш	3,500,000	3,500,000	"ОЗЗО" ХХК-ийн DJL хөгжмийн академи
4	Аймгийн сургагч багшийн зардал	4ш	250,000	1,000,000	Соёл, урлаг, аялал, жуулчлал, залуучуудын газар
5	Басс гитар /тоглолтын, дагалдах хэрэгслийн хамт/	1ш	1,470,000	1,470,000	Хөгжимт жүжгийн театр
6	Соль гитар /тоглолтын, дагалдах хэрэгслийн хамт/	1ш	1,370,000	1,370,000	
7	Бөмбөр /ком/	1ш	2,500,000	2,500,000	
Нийт дүн				20,640,000	